

# “МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 18-ны өдөр

№ ..... 37/02

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2 заалт, 47 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.12 заалт, “Монос хүнс” ХК-ийн дүрмийн 11 дүгээр зүйлийн 11.5, 11.6 заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 28 тоот тогтоол, 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монос хүнс” ХК-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас 37,4% (гучин долоо аравны дөрвөн хувь)-иар буюу 408,850,428 (дөрвөн зуун найман сая найман зуун тавин мянга дөрвөн зуун хорин найм) төгрөгийг мөнгөн хэлбэрээр тооцож, нэгж хувьцаанд 1 төгрөгийн ногдол ашгийг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх бүртгэлийн өдрөөр тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас холбогддох хууль тогтоомжийн дагуу хувь хүний болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХХК-аар дамжуулан 2021 оны 04 сарын 01-ний өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулан олгохыг Гүйцэтгэх захирал (А.Отгондарь), Ерөнхий нягтлан бодогч (Ц.Дэлгэрмаа) нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавих, ногдол ашиг тараах мэдээллийг зохих журмын дагуу хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Н.Цагаанхүү)-д даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

Л.ХҮРЭЛБААТАР

